

MIRIM
INNOVATION & CONSULTANT

2022-2025

МОНГОЛ УЛС ДАХЬ ЭЛЕКТРОН ТАМХИНЫ ИМПОРТ БА НАСАНД ХҮРСЭН ХЭРЭГЛЭГЧДИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ХАНДЛАГА

Монгол Улсад (МУ) тамхины хэрэглээ өндөр түвшинд хадгалагдсаар байна. 2025 оны байдлаар насанд хүрсэн хүн амын ойролцоогоор 27.9% нь тамхи татдаг бөгөөд энэ нь олон улсын дунджаас өндөр үзүүлэлтэд тооцогдож байна. Хүйсийн хувьд хэрэглээний ялгаа тодорхой ажиглагдаж байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн 51%, эмэгтэйчүүдийн 6.7% нь тамхи татаж байна (*Shagdarsuren, T., & Jadamba, T., 2025*).

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын (ДЭМБ) 2025 оны мэдээллээр МУ-д жил бүр ойролцоогоор 4300 хүн тамхины хэрэглээтэй холбоотой шалтгааны улмаас нас барж байгаа нь хүн амын эрүүл мэндэд ноцтой ачааллыг үүсгэж буйг илтгэнэ. 2025 оны “Монгол дахь өсвөр насныхны электрон тамхи хэрэглээний судалгаа"-ны үр дүнгээс харвал өсвөр насны хүүхэд, залуучуудын 60% нь электрон тамхи хэрэглэж үзсэн ба гурван хүүхэд тутмын нэг нь тогтмол хэрэглэдэг нь тогтоогджээ. Тогтмол хэрэглэгч хүүхдүүдийн 20% нь өдөрт 10 ба түүнээс дээш удаа электрон тамхи хэрэглэдэг бөгөөд энэ нь никотинд донтож, насан туршийн хэрэглээ үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байгааг харуулж байна (*ДЭМБ, 2025*).

Өнөөгийн байдлаар МУ-д электрон тамхины хэрэглээ, импорт, сурталчилгаа, борлуулалтыг тусгайлан зохицуулсан иж бүрэн хууль эрх зүйн орчин бүрдээгүй байна. Үүний улмаас өсвөр үе, залуучуудын хэрэглээг үр дүнтэй хязгаарлах, зах зээлийн нийлүүлэлтийн урсгалыг хянах, бүтээгдэхүүний агууламж, чанар, хэрэглээний эрсдэлийг үнэлэх боломж хязгаарлагдмал байна. Энэхүү судалгаа нь 2022–2025 онд МУ-д орж ирсэн тамхины бүтээгдэхүүний импортын мэдээлэлд үндэслэн электрон тамхины зах зээлийн бодит хэмжээ, бүтцийг тодорхойлж, улмаар хэрэглэгчдийн хүн амзүйн үзүүлэлтээр ангилан, тодорхойлно.Судалгааны үр дүнг электрон тамхитай тэмцэх бодлого боловсруулах, олон нийтийн эрүүл мэндийг урьдчилсан сэргийлэх хөтөлбөрүүдэд ашиглах боломжтой.

Уг судалгаанд анхдагч болон хоёрдогч өгөгдлийг хослуулан ашиглалаа. Анхдагч өгөгдлийг 2025 онд МИРИМ Консалтант ХХК-аас улс даяар зохион байгуулсан 3000 насанд хүрсэн иргэнийг хамарсан санамсаргүй түүврийн судалгаагаар цуглуулсан. Хоёрдогч тоон өгөгдөлд Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын 2022–2025 оны импортын статистик, ДЭМБ-ын Монгол дахь Суурин төлөөлөгчийн газрын 2025 оны судалгааны дүн, “Тамхины хор хөнөөлийг бууруулах дэлхийн төлөв байдлын тайлан" зэрэг олон улсын судалгааны үр дүн, мэдээллийг ашигласан болно.

Тамхины импортын тойм

Монгол Улсын тамхины импортын зах зээлд **янжуур тамхины эзлэх хувь давамгайлсаар байгаа** нь тамхины импортын мэдээллээс тод харагдаж байна (*Хүснэгт 1*). 2022 онд янжуур тамхины импорт 331.97 тэрбум төгрөг, 2023 онд 248.70 тэрбум төгрөг байсан бол 2024 онд дахин өсөж 374.99 тэрбум төгрөгт хүрсэн нь янжуур тамхи эрэлттэй хэвээр байгааг илтгэж байна. Түүнчлэн 2022–2024 онуудын импортын бүтцийн дундаж үзүүлэлтээр янжуур тамхи нийт тамхины импортын зах зээлийн 92%-ийг дангаараа бүрдүүлж байгаа нь бусад төрлийн тамхины бүтээгдэхүүнтэй харьцуулахад зах зээлд хэт давамгай байр суурь эзэлсээр байгааг харуулж байна.

Үүнтэй **зэрэгцэн электрон тамхины импорт сүүлийн жилүүдэд эрчимтэй тэлж, тамхины хэрэглээний бүтэц шинэ чиг хандлага руу шилжиж байгааг харуулж байна**. Хүснэгт 1-ээс харахад, 2022 онд 12.27 тэрбум төгрөг байсан электрон тамхины импорт 2023 онд 21.65 тэрбум төгрөгт, 2024 онд 57.60 тэрбум төгрөгт хүрч, х**оёр жилийн дотор 4.7 дахин өссөн** байна. Хэдийгээр электрон тамхи нь нийт импортын бүтцэд одоогоор 7.8%-ийг эзэлж байгаа ч огцом өсөлтийн хурд нь цаашид зах зээлийн бүтэц, хэрэглээний хэв маягт томоохон өөрчлөлт авчрах төлөвийг харуулж байна.

Харин **дүнсэн болон шиша тамхины импорт сүүлийн жилүүдэд огцом хумигдаж**, тамхины нийт импортын бүтцэд маш бага хувийг эзлэх болжээ. Дүнсэн тамхины импорт 2022 онд 2.03 тэрбум төгрөг байсан ч 2023, 2024 онуудад ердөө 0.01 тэрбум төгрөг болж багассан нь энэ төрлийн хэрэглээ үндсэндээ шахагдаж буурсныг харуулна. Шиша тамхины импорт мөн адил 2022–2024 онуудад 0.03 тэрбум төгрөгийн түвшинд тогтвортой байсан ч 2025 оны эхний 8 сарын байдлаар шиша тамхи импортлогдоогүй байна (*Хүснэгт 1*).

Хүснэгт 1. Тамхины импортын хэмжээ, тамхины төрөл, тэрбум төгрөгөөр

Нэр	2022 он	2023 он	2024 он	2025 оны 8-р сар	Импортын тамхины бүтэц, хувиар
Янжуур	331.97	248.70	374.99	277.12	92.0%
Электрон	12.27	21.65	57.60	18.55	7.8%
Дүнсэн	2.03	0.01	0.01	0.22	0.2%
Шиша	0.03	0.03	0.03	-	0.0%
Нийт	**346.31**	**270.38**	**432.64**	**295.89**	**100.0%**

Өгөгдлийн эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

МУ-ын янжуур тамхины импортын дийлэнх хэсэг нь БНСУ болон Казахстанаас хамаарч байна. Зураг 1-аас харахад, 2022–2025 оны дундаж үзүүлэлтээр нийт импортын 49.1%-ийг БНСУ, 44.0%-ийг Казахстан тус тус бүрдүүлж, хоёр улс нийлээд зах зээлийн 93%-ийг бүрдүүлж байна. Түүнчлэн Япон улсаас нийт импортын 3.1%-ийг, бусад улсаас 3.8%-ийг импортолж байгаа нь МУ-ын янжуурын тамхины импортын зах зээл үндсэндээ хоёр улсад төвлөрч байгааг харуулж байна.

Харин *Зураг 2*-ын үр дүнгээс харахад, **Esse брэнд Монголын янжуур тамхины импортын зах зээлд голлох байр суурийг эзэлж байна**. 2022–2025 оны дундаж үзүүлэлтээр Esse нийт импортын 41.8%-ийг бүрдүүлж, зах зээлийн бараг тэн хагасыг дангаараа хянаж байна. Үүний дараа Caster (17.3%) болон Mevius (14.9%) брэндүүд орж, нийлээд зах зээлийн гуравны нэгээс илүүг бүрдүүлж байна. Харин LD (9.3%) болон Parliament (5.4%) брэндүүд харьцангуй бага хувийг эзэлж, зах зээлд дунд ба доод түвшний оролцогчдын байр суурийг эзэлж байна. “Бусад” брэндүүд нийтдээ 11.3%-ийг эзэлж байгаа нь олон жижиг брэндүүд нийлсэн ч том тоглогчдын давамгайллыг сорих хэмжээний нөлөө үзүүлээгүйг харуулж байна.

Электрон тамхины дийлэнх нь БНХАУ-аас импортлогдож байна. *Зураг 3*-аас харахад, 2022–2025 оны дундаж үзүүлэлтээр нийт электрон тамхины 81.3% нь БНХАУ-аас импортлогдож, зах зээлийг бараг дангаараа бүрдүүлжээ. Үүний дараа Хонконг 15.1%-ийг эзэлж, хоёр дахь том нийлүүлэгч болж байгаа бол Их Британи (2.6%), АНУ (0.9%), Швейцар (0.1%) болон бусад улс (0.05%) багахан хувийг бүрдүүлж байна. Энэхүү бүтэц нь МУ-ын электрон тамхины импорт үндсэндээ БНХАУ болон Хонконгоос хамааралтай байгааг харуулж байна.

Зураг 1. Янжуур тамхины импортын бүтэц, 2022-2025.8 оны дундаж хувиар, илгээгч улсаар



Зураг 2. Янжуур тамхины импортын бүтэц, 2022-2025.8 оны дундаж хувиар, брэндээр



Өгөгдлийн эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Электрон тамхины нэр төрлийн хувь **долон брэндийн электрон тамхи импортолж байгаа ч Waka брэнд давамгайлж байна**. 2022–2025 оны дундаж хувиар Waka брэнд нийт импортын зах зээлийн 36.6%-ийг эзэлж, зах зээлийн гуравны нэгээс илүүг дангаар бүрдүүлсэн байна. Түүнчлэн Relx (13.3%), Moti (6.9%), Luxe S (4.5%), Axi (4.5%), Snowplus (3.8%), Row (3.4%), Apex (3.2%) зэрэг брэндүүд импортын зах зээлийг бага багаар хуваж, бүрдүүлсэн байна. “Бусад” ангилал дангаараа 23.6%-ийг эзэлж, гаалийн статистикт нийт 20 орчим брэнд бүртгэгдсэн нь электрон тамхины импорт харьцангуй олон төрөл, өрсөлдөөнтэй бүтэцтэй болсныг харуулж байна.

Зураг 3. Электрон тамхины импортын бүтэц, 2022-2025.8 оны дундаж хувиар, илгээгч улсаар



Зураг 4. Электрон тамхины импортын бүтэц, 2022-2025.8 оны дундаж хувиар, брэндээр



Насанд хүрсэн иргэдийн электрон тамхины хэрэглээний хандлага

Импортын тоон мэдээллээс харахад, **электрон тамхины импортын биет хэмжээ огцом өсөлттэй, зах зээлд хурдтай нэмэгдэж буй төрөл болж байна**. *Хүснэгт 2*-аас харахад, электрон тамхины импортын биет хэмжээ 2022 онд 37.9 тонн байсан бол 2023 онд 159.3 тонн, 2024 онд 371.8 тонн болж, 2022 онтой харьцуулахад 2024 онд арав дахин өссөн байна. Тоо ширхгээр нь авч үзвэл 2023 онд 1.55 сая ширхэг электрон тамхи импортлогдож, хамгийн өндөр түвшинд хүрсэн бол 2024 онд 28.8 мянга, 2025 оны эхний 8 сарын байдлаар 53.4 мянган ширхэг болж, хэлбэлзсэн байна.

2024 оны байдлаар авч үзвэл, Монгол Улсын 18 болон түүнээс дээш насны нэг иргэнд 0.164 кг (жингээр) болон 0.013 ширхэг электрон тамхины импорт ноогдож байгаа нь өмнөх онуудтай харьцуулахад нэг хүнд ноогдох хэмжээ огцом өссөн байгааг илтгэнэ. *Зураг 5*-ын мэдээллээс харахад, нэг хүнд ногдох электрон тамхины импортын жин 2022 онд 0.017 кг, 2023 онд 0.071 кг байсан бол 2024 онд 0.164 кг болж, 2.3 дахин нэмэгдсэн байна. Харин ширхгээр бүртгэгдсэн электрон тамхины импортын хувьд, 2023 онд 0.695 ширхэг хүрч хамгийн өндөр түвшинд хүрсэн боловч 2024 онд 0.013 ширхэг болж эрс буурсан нь импортын барааг бүртгэх аргачлал, ангилал болон савлагааны нэгжид гарсан өөрчлөлттэй холбоотой байх магадлалтай.

Хүснэгт 2. Тамхины импортын биет хэмжээ, төрлөөр

Нэр	Хэмжих нэгж	2022	2023	2024	2025 оны 8-р сар
Янжуур	мянган ширхэг	4,861,605.7	3,768,700.1	5,535,910.7	3,931,419.2
Электрон	кг	37,974.4	159,285.0	371,750.7	118,575.3
Дүнсэн	кг	121,557.8	34.1	44.4	12,035.2
Шиша	кг	393.0	264.6	352.5	-

Өгөгдлийн эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Зураг 5. Монгол Улсын насанд хүрсэн нэг иргэнд ноогдох электрон тамхины импортын хэмжээ



Электрон тамхины хэрэглээний түвшин нь насанд хүрсэн иргэдийн дунд харьцангуй өндөр байгааг импортын тоон мэдээлэл харуулж байна. МИРИМ Консалтант ХХК 2025 оны 5-10 сарын хооронд 3000 насанд хүрсэн иргэдээс асуумж судалгаа авч, иргэдийн дунд электрон тамхины хэрэглээ хэр байгааг тандан судалсан юм. Судалгаанд оролцогчдын 43.8% нь электрон тамхи хэрэглэдэг нь тогтоогдсон.

Хүйсийн хувьд эмэгтэйчүүдээс илүү эрэгтэйчүүд электрон тамхийг тогтмол хэрэглэж байна. Тодруулбал, судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 19.0% нь электрон тамхи байнга хэрэглэдэг, 13.9% нь заримдаа хэрэглэдэг гэж хариулсан бол эмэгтэйчүүдийн 2.0% нь байнга, 8.4% нь ихэвчлэн хэрэглэдэг байна (*Зураг 6*).

Зураг 6. Электрон тамхины хэрэглээ, хүйсээр, n=3000

Өгөгдлийн эх сурвалж: МИРИМ Консалтант ХХК, Тамхины хэрэглээний судалгаа

Залуучуудын дунд электрон тамхины хэрэглээ өндөр байна. Судалгаанд оролцсон 18-24 насны бүлгийн оролцогчдын 15.7% нь байнга хэрэглэдэг бол, 21.1% нь ихэвчлэн хэрэглэдэг, 31.6% нь хаяа хэрэглэдэг, 31.6% нь электрон тамхийг огт хэрэглэдэггүй гэж хариулжээ. Харин нас ахих тусам электрон тамхины хэрэглээ буурч, 25-34 насны бүлэгт огт хэрэглэдэггүй хүний эзлэх хувь 56.6%, 35-44 насанд 74.5%, 45-аас дээш насны бүлэгт 84.1% болж байна. Энэхүү тоон үзүүлэлт нь электрон тамхины хэрэглээ голлон залуу насны бүлгийн дунд түгээмэл байгааг тодорхой харуулж байна (*Зураг 7*).

Зураг 7. Электрон тамхины хэрэглээ, насны бүлгээр



Өгөгдлийн эх сурвалж: МИРИМ Консалтант ХХК, Тамхины хэрэглээний судалгаа

Дүгнэлт

Монгол Улсад тамхины хэрэглээ өндөр хэвээр байна. Насанд хүрэгчдийн дунджаар 27.9% нь тамхи татдаг бөгөөд тамхины хэрэглээ хүн амын эрүүл мэндэд ноцтой ачаалал үүсгэж байна. Өсвөр үе, залуучуудын дунд электрон тамхины хэрэглээ нэмэгдэж, тогтмол хэрэглэгчдийн дунд никотинд донтолт үүсэх эрсдэл өндөр байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын тамхины импорт хэлбэлзэлтэй ч ерөнхийдөө өсөх хандлагатай байна. Тамхины импортод янжуур тамхи давамгай буюу нийт импортын 92.0%-ийг янжуур тамхи бүрдүүлж байна. Харин электрон тамхины импорт сүүлийн жилүүдэд эрчимтэй өсөж, 2022 онд 12.27 тэрбум төгрөг байсан нь 2024 онд 57.60 тэрбум төгрөг болж, зөвхөн хоёр жилийн дотор 4.7 дахин нэмэгдсэн нь зах зээлийн бүтцэд шинэ чиг хандлага үүсгэж байгааг илтгэнэ. Электрон тамхины импортын дийлэнх нь БНХАУ-аас (81.3%) орж ирж, Waka брэнд зах зээлийн 36.6%-ийг дангаар эзэлж байна. Энэ нь электрон тамхины импорт харьцангуй олон брэнд, төрөлтэй байна.

Насанд хүрсэн иргэдийн дунд электрон тамхины хэрэглээ харьцангуй өндөр боловч нас, хүйсийн хувьд ялгаатай байна. МИРИМ Консалтант ХХК-аас 2025 онд 3000 иргэнээс санамсаргүй түүврээр явуулсан судалгаагаар нийт оролцогчдын 43.8% нь электрон тамхи хэрэглэдэг нь тогтоогдсон. Мөн судалгааны үр дүнгээс үзвэл, эрэгтэйчүүдийн дунд электрон тамхийг байнга эсвэл ихэвчлэн хэрэглэдэг хувь эмэгтэйчүүдээс илүү өндөр байна. Насны хувьд залуучуудын дунд хэрэглээ хамгийн өндөр бөгөөд 18–24 насны бүлгийн оролцогчдын 68.4% ямар нэг байдлаар татаж үзсэн ба үүнийг задалж харвал 15.7% нь тогтмол, 21.1% нь ихэвчлэн, 31.6% нь хаяа хэрэглэдэг гэж хариулсан байна. Нас ахих тусам хэрэглээ буурч, 45-аас дээш насны бүлэгт огт хэрэглэдэггүй хүний эзлэх хувь 84.1% байгаа нь электрон тамхины хэрэглээ голлон залуу насныхны дунд түгээмэл байгааг харуулж байна.

Ашигласан материалын жагсаалт

- GSTHR. (2024). *Global State of Tobacco Harm Reduction*. “Mongolia: Country Profile." Knowledge-Action-Change: https://gsthr.org/countries/profile/mng/1/-ээс Гаргасан
- Shagdarsuren, T., & Jadamba, T. (2025). *Mongolia – Tobacco Industry Interference Index 2025*. Ulaanbaatar: WHO Country Office of Mongolia; Ministry of Health; National Institute for Public Health; Global Center for Good Governance in Tobacco Control.
- Гаалийн ерөнхий газар. (2022–2025). *Тамхины импортын статистик мэдээлэл*. Улаанбаатар: https://www.gaali.mn/.
- ДЭМБ. (2025). *ДЭМБ Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар*. Монгол дахь өсвөр насныхны Vape хэрэглээний судалгаа.: https://www.who.int/mongolia/mn/home/25-05-2025-mongolia-steps-up-fight-against-tobacco-and-e-cigarettes-ээс Гаргасан
- МИРИМ Консалтант ХХК. (2025). *Тамхины хэрэглээний судалгааны өгөгдөл*. Улаанбаатар: МИРИМ Консалтант ХХК.
- Монгол Улсын Их Хурал. (2005). *Тамхины хяналтын тухай хууль*. Улаанбаатар: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.